



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 572

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 нэрийн, нийт 5,236,836.30 (таван сая хоёр зуун гучин зургаан мянга найман зуун гучин зургаан төгрөг гучин мөнгө) төгрөгийн балансын үнэ, 2,315,859.18 (хоёр сая гурван зуун арван таван мянга найман зуун тавин есөн төгрөг арван найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Биологийн хүрээлэнд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал Ч.Чимэдрагчаа, Биологийн хүрээлэнгийн захирал Д.Гантулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132000450
26-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН БАЛАНСААС
БИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон огноо	Хэм- жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хашаа /хүдрийн/	2008/12/31	ш	10335	265.78	2,746,836.30	1,678,359.18	1,068,477.12
2	Хашаа /хүдрийн/	2008/12/31	ш	1500	1,500.00	2,250,000.00	637,500.00	1,612,500.00
3	Хүдэр /амьтан/	2019/12/01	ш	3	80,000.00	240,000.00		240,000.00
	НИЙТ ДҮН			11838	81,765.78	5,236,836.30 (таван сая хоёр зуун гучин зургаан мянга найман зуун гучин зургаан төгрөг гучин мөнгө)	2,315,859.18 (хоёр сая гурван зуун арван таван мянга найман зуун тавин есөн төгрөг арван найман мөнгө)	2,920,977.12 (хоёр сая есөн зуун хорин мянга есөн зуун далан долоон төгрөг арван хоёр мөнгө)